

ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: Улаанбаатар лифт НӨҮГ

Нэг. Ажлын зорилго

Байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд иргэд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах, зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийт ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлэв.

Хоёр. Хэрэгжүүлсэн ажил

2.1. Лифтэнд аюулгүй зорчих санамж байршуулсан

Гэрээт 66 ААНБ, СӨХ-дын удирдлагуудыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

- Мөн тус хугацаанд 91 ААНБ, СӨХ-дын 472 цахилгаан шатанд техникийн ээлжит магадлалын ажлыг хийж, илэрсэн зөрчлийг лифт ашиглагчид танилцуулж, зөрчлийг хэрхэн арилгах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

Мөн лифтээр үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах, лифтийг зөв зохистой ашиглах мэдлэг, дадлыг нэмэгдүүлэх зорилгоор “Аюулгүй ажиллагааны санамж”-ийг боловсруулж гэрээт СӨХ-дод хүргүүлж байршуулсан. “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын өөрийн сайт болон фейсбүүк хуудсанд байнга байршуулан нийтэд сурталчилж байна. Аюулгүйн санамжуудыг Нийслэлийн 4 байршилд байгаа явган хүний гүүрэн гарцнуудын 8 лифтэнд байршуулсан. Мөн цахилгаан шатаар зорчих үедээ иргэдтэй байнга харилцаж цахилгаан шаттай хэрхэн харилцах, хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөөг тогтмол өгч ажилласан.



Уг ажлын үр дүнд лифтээр зорчиж буй иргэдэд аюулгүй ажиллагааны зөвлөмжийг тогтмол хүргэх, лифтийг зөв ашиглах дадлыг хэвшүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн.

Мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44 дүгээр зарлигаар жил бүрийн 5, 9 дүгээр сарын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласантай холбогдуулан Ойн газраас баталсан “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээг зохион байгуулах удирдамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Айцын аманд 2022, 2023 онд тарьсан мод, сөөгийн усалгаа, арчилгаа, нөхөн тарилтыг хийх арга хэмжээнд байгууллагын нийт албан хаагчид идэвхтэй оролцлоо.



2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр “Нэг албан хаагч-Нэг мод” арга хэмжээнд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороонд байрлах Айцын амны ойжуулалтын талбайд байгууллага хамт олноороо модны нөхөн тарилт, арчилгаа, цэнэг усалгааг хийсэн.



Байгаль орчноо хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор байгууллагын орчинд нийт 25 ширхэг мод тарьж, арчилгаа хамгаалалтыг зохион байгуулсан.

Мод тарих үйл ажиллагаанд ажилтан, албан хаагчид оролцож, хүрээлэн буй орчноо хамгаалах, байгальд ээлтэй зөв дадлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулсан.

Энэхүү ажлын үр дүнд байгууллагын орчны ногоон байгууламж нэмэгдэж, цэвэр, тохилгог орчин бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан бөгөөд ажилтан, албан хаагчдын байгаль орчинд хандах хариуцлага, оролцоог нэмэгдүүлсэн.

- Байгууллагын нийт ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, тогтмол дасгал хөдөлгөөнтэй байлгах зорилгоор Улаанбаатар хотын ШУЗТөвтэй хамтран

сард 2 удаа ШШГЕГ-ын харьяа “Сүлд” БТСХороотой гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

- Байгууллагын нийт ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны дасгал хөдөлгөөн тогтмол хийж байна.



- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоо олон улсад сурталчлах, нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортоор тогтмол хичээллэж, бие бялдраа чийрэгжүүлэн, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/402 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлт 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан бөгөөд байгууллагын нийт албан хаагчид идэвхтэй оролцлоо.



- Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Улаанбаатарын өвлийн наадам-2025” арга хэмжээнд хамт олноороо оролцлоо.



- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33 дугаар захирамжийн хүрээнд манай байгууллагын нийт 8 албан хаагчид, тус хорооны хэсгийн ахлагч нар Баянзүрх дүүргийн 8-р хорооны 10-р хэсгийн нутаг дэвсгэрт байрлах гэр хорооллын 253 айл өрхүүдэд пийшин зуухны галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэх, түүхий нүүрс ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалтыг зохион байгуулж, судалгаа гарган, зөвлөгөө зөвлөмж хүргэх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Тус судалгааны хүрээнд 185 айл өрхийн мэдээллийг цахимаар, 68 айл өрхийн мэдээллийг цаасаар гаргаж хорооны хэсгийн ахлагчид хүлээлгэн өглөө.



- Байгууллагын гадна хашаан дахь мод, зүлгийг усалж, шарилжийг тухай бүр түүж, ногоон байгууламжийг бүтээн ажиллаж байна.



- Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” А/354 дүгээр захирамжийн дагуу байгууллагын хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 28-аас 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Үүнд:

- 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн талбай, өөрийн эзэмшлийн хашаан доторх хог хаягдал, байгууллагын хана, фасад, цонх, хаяг, хаягийн байгууламж, сандал, хогийн сав, үүдийг угааж, өнгө үзэмжийг сэргээсэн. Цэвэрлэгээний ажилд байгууллагын 17 ажилтан, албан хаагчид бүрэн хамрагдаж идэвхтэй оролцлоо.



- 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Энхтайвны өргөн чөлөөнөөс Сөүлийн гудамж хүртэл Улсын Их Дэлгүүрийн чанх урд талын гудамж /Цэрэндоржийн гудамж/ хүртэлх зам, талбай, гуу жалганд үүссэн хог хаягдлыг цэвэрлэсэн.



